

## ХОРШООНЫ ГИШҮҮНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ, ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ГЭРЭЭ

.....  
(Байрлал)

### ГЭРЭЭНИЙ ДУГААР .....

#### НЭГ: ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү гэрээг нэг талаас “.....” хоршоо ( цаашид хоршоо гэж нэрлэгдэх) төлөөлж хоршооны ..... ажилтай ..... овогтой ..... , нөгөө талаас тус хоршооны гишүүн( цаашид гишүүн гэж нэрлэгдэх) ..... овогтой ..... -ны ..... нар харилцан хоршооны гишүүний бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх,үйлчилгээ авах талаар тохиролцож энэхүү гэрээг байгууллаа.

Хоршоо. хоршооны гишүүн нь бүтээгдэхүүн. үйлчилгээ харилцан нийлүүлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах бөгөөд цаашдын тогтвортой хамтын ажиллагааг хөгжүүлэх. үүрэг хариуцлагаа бэжжүүлэхэд бэжжүүлэхэд гэрээний зорилго оршино

Гишүүдээс хоршоонд бэлтгэн нийлүүлэх бүтээгдэхүүн, хоршооноос гишүүний авах үйлчилгээний хэмжээ, үнийн дүнг илэрхийлсэн жил, жилээр нарийвчлан тодорхойлж тодотгосон хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно

#### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

Энэхүү гэрээ нь тухайн гишүүний хоршооны гишүүн байх бүхий л хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөх бөгөөд харин хавсралтыг жил бүрийн нийлүүлэх бүтээгдэхүүн хоршооноос авах үйлчилгээний тоо хэмжээг тухай бүр тохиролцон өөрчилнө.

#### ГУРАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ЭРХ

Хоршооны гишүүн нь хавсралтанд заасан тоо хэмжээ, чанарын бүтээгдэхүүнийг тухайн жилд өөрийн аж ахуйгаас бэлтгэн дурдсан хуваарийн дагуу бүрэн хэмжээгээр бэлтгэн нийлүүлнэ.

Хоршоо нь гишүүний бэлтгэн нийлүүлж буй бүтээгдэхүүнийг өөрийн байранд гэрээт хугацаанд саадгүй хүлээн авна.

Хоршоо нь гишүүнд үзүүлэхээр тодорхойлсон үйлчилгээг гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу нийлүүлэх үүрэгтэй ба гишүүн нь тухайн үйлчилгээг мөн тухай бүр саадгүй авах үүрэгтэй болно.

Хоршоо нь гэрээт гишүүнтэй харилцах харилцаа, түүний эрх ашгийг гэрээ байгуулаагүй гишүүд болон гишүүн бус этгээдийнхээс давуу нөхцөл эрх боломжоор ханган тэргүүн ээлжинд шийдвэрлэж байх үүрэгтэй болно.

Гишүүн нь өөрийн бэлтгэсэн бүтээгдэхүүнийг өөрийн тээврээр хоршооны заасан газар, байранд хүргэх үүрэгтэй.

Хоршоо нь гэрээний үүргийн дагуу (гэрээнд заасан тоо хэмжээ, чанарын шаардлагыг хангасан) тогтоосон хугацаанд гишүүний бэлтгэсэн бүтээгдэхүүнийг хүлээн аваагүй тохиолдолд түүнийг нийлүүлэх үүргээс чөлөөлөгдөх эрхтэй.

Гэрээний хугацаа, тоо хэмжээ, чанарын шаардлагыг зөрчсөн тохиолдолд гишүүний бэлтгэсэн бүтээгдэхүүнийг хүлээн авахаас татгалзах эрхийг хоршоо эдэлнэ.

Хоршоо гишүүнд үзүүлэх үйлчилгээг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд уг

үйлчилгээг бусдаас авах эрхийг эдэлнэ.

### **ДӨРӨВ. ҮНЭ, ТООЦООНЫ ЖУРАМ**

Хоршоо нь гишүүний бэлтгэн нийлүүлсэн бүтээгдэхүүний үнийг тухай бүр нь бүрэн хэмжээгээр саадгүй төлнө.

Хоршоо гишүүн буюу хоёр тал нь үнийн дүнгээс тодорхой хэмжээний урьдчилгаа олгох, үнийг хэсэгчлэн төлөх талаар тохиролцох боломжтой ба энэ талаар гэрээний хавсралтанд дурдана

Хоршооноос үзүүлсэн үйлчилгээний үнийг гишүүн нь тухай бүр төлөх ба зээлээр үйлчлүүлэх бол мөн хавсралтанд зааж байна.

Харилцан бэлтгэн нийлүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг тухайн орон нутаг, цаг үеийн ханшинд тулгуурлан 2 тал харилцан тохиролцоно.

### **ТАВ. ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА**

Гишүүн нь хоршоонд бүтээгдэхүүн нийлүүлэх үүргээ бүрэн буюу хэсэгчлэн биелүүлээгүй нөхцөлд хугацаа хэтэрсэн хоног тутамд дутуу үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хоршоонд төлнө.

Хоршоо нь гишүүнд гэрээнд заасан үйлчилгээгээ бүрэн буюу хэсэгчлэн үзүүлээгүй тохиолдолд дээрх зарчмаар гишүүнд алданги төлнө.

Харилцан хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас гэрээт нөгөө талд учруулсан хохирол нь алданги төлснөөр нөхөгдөхгүй бол уг хохирлыг буруутай тал бүрэн хэмжээгээр барагдуулна.

Санхүүгийн хариуцлага хүлээснээр бүтээгдэхүүн нийлүүлэх, үйлчилгээг нөхөн нийлүүлэх үүргээс чөлөөлөгдөх эсэхийг талууд тухайн үед харилцан зохицуулна.

### **Зургаа. Бусад зүйл**

Энэхүү гэрээ нь 2 тал гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө. Гэрээг 2 хувь үйлдсэн бөгөөд ижил хэмжээнд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Гэрээгээр зохицуулаагүй асуудлууд болон харилцан тохиролцож чадахааргүй маргаан гарсан үед Иргэний хууль болон бусад эрх зүйн баримт бичгийн дагуу шийдвэрлэж байна.

### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

“.....”

Хоршоог төлөөлж

..... ажилтай

.....

.....

/гарын үсэг/

20..... оны ..... сарын .....өдөр

“.....”

Хоршооны гишүүн

..... овогтой

.....

.....

/гарын үсэг/

<b>РД</b>									
-----------	--	--	--	--	--	--	--	--	--

20..... оны ..... сарын .....өдөр

*Хоршооны гишүүний бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх, үйлчилгээ авах тухай  
 ..... оны ..... сарын ..... өдөр байгуулсан ..... тоот гэрээний хавсралт №1*

..... ХОРШООНЫ ГИШҮҮНИЙ  
 ..... ОНД БҮТЭЭГДЭХҮҮН БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ,  
 ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ТУХАЙ

**Гишүүндээ хоршооноос үзүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээ**

Д/Д	Үйлчилгээ бүтээгдэхүүний нэр төрөл	Х/Н	Тоо хэмжээ	Чанарын ерөнхий шаардлага	Урьдчилан тохиролцсон үнэ, ханш		Нийлүүлэх хугацаа	Зээлээр олгох эсэх, хэмжээ
					Нэгжийн	Нийт		

**Гишүүнээс хоршоондоо нийлүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээ**

Д/Д	Бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл	Х/Н	Тоо хэмжээ	Чанарын ерөнхий шаардлага	Урьдчилан тохиролцсон үнэ, ханш		Нийлүүлэх хугацаа	Урьдчилгаа олгох эсэх, хэмжээ
					Нэгжийн	Нийт		

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**Хоршоог төлөөлж**

**Хоршооны гишүүн**

..... ажилтай  
 .....  
 .....

..... ОВОГТОЙ  
 .....  
 .....

*/гарын үсэг/  
 20..... оны ..... сарын ..... өдөр*

*/гарын үсэг/  
 20..... оны ..... сарын ..... өдөр*

**Жич: Гэрээний хавсралтыг жил бүр 2 хувь үйлдэнэ.**

